

“ЛЭНДМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Тогтоол

2019 оны 8 дугаар сарын 15-ны өдөр

№ 19/40

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга
сонгох тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 10.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн Үйл ажиллагааны журмын 7.1 дэх хэсэг, Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02 тоот дүгнэлт, санал хураалтын дүн, ТУЗ-ийн 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн дарга Очирсүрэн овогтой Болдбаатар нь ТУЗ-ийн даргаас өөрийн санаачилгаар чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул энэхүү тогтоол гарсан өдрөөр тасалбар болгон түүний ТУЗ-ийн даргын бүрэн эрхийг дуусгавар болгож ТУЗ-ийн даргаас чөлөөлсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дэх заалтаар ТУЗ-ын даргыг чөлөөлсөнтэй холбогдуулан Компанийн ТУЗ-ын даргаар Б.Дэлгэржаргал /РД:ХБ73070664/-ыг сонгосугай.
3. Компанийн ашиг сонирхолыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, компанийн засаглалын журмуудтай нийцүүлэн ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.
4. Компанийн ТУЗ-ийн даргаар Б.Дэлгэржаргал сонгогдсон болохыг зохих журмын дагуу Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон олон нийтэд мэдээлэхийг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ийн гишүүд:



/О.БОЛДБААТАР/

/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

/В.БАЯРСАЙХАН/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

/С.БОРГИЛ/

/Н.ЦЭВЭГМИД/

/С.ЭНХ-АМГАЛАН/

/Ч.НОМИН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 15-ны өдөр

№ 19/41

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.6 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хурлаас санал болгосныг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирал Булган овогтой Гантулга нь 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Компанийн Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул энэхүү тогтоол гарсан өдрөөр түүний Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоож, үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Б.Гантулгыг ажлаас нь чөлөөлж байгаатай холбоотой түүнтэй байгуулсан Конрактын гэрээг дуусгавар болгох тохиролцоо хийх, түүний ажлын гүйцэтгэлийг үнэлж зохих урамшуулалын хэмжээг тодорхойлон дараагийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхийг ТУЗ-ийн дарга /Б.Дэлгэржаргал/-д даалгасугай.
3. Компанийн Гүйцэтгэх захирал албан тушаалд Очирсүрэн овогтой Болдбаатар (ЙЮ80100817)-ыг томилсугай.
4. Гүйцэтгэх захирлын ажил, үүргийг хүлээлцэх арга хэмжээг ажлын 5 өдрийн дотор зохион байгуулж, хүлээн авахыг Гүйцэтгэх захирал О.Болдбаатарт даалгасугай.
5. Компанийг төлөөлж Гүйцэтгэх захиралтай Хөдөлмөрийн контрактын гэрээ болон Нууцлалын гэрээ байгуулахыг ТУЗ-ийн дарга /Б.Дэлгэржаргал/-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, энэхүү өөрчлөлтийн талаар Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Олон нийтэд мэдэгдэх болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт шинэ гүйцэтгэх захирлын мэдээллийг бүртгүүлэх ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн дотор зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/-т даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 15-ны өдөр

№ 19/42

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зарим хороодын хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.1, 14 дүгээр зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсантай холбогдуулан ТУЗ-ийн зарим хороодын бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсугай. Үүнд:

- а. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хороо:

Хорооны дарга: Б.Дэлгэржаргал;

Гишүүд: О.Болдбаатар;
В.Баярсайхан;
Н.Цэвэгмид;
Ч.Номин.

- б. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: С.Эпх-Амгалан;

Гишүүд: С.Боргил;
Ч.Номин.

2. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудаст байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулах, Санхүүгийн Зохицуулах хороо болон олон нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар), ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг) нарт үүрэг болгосугай.

